2018 оны 06 сарын 27 өдөр Төрийн ордон, Улаанбаатар хот

# ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “дайчилгааны” гэснийг “дайчилгаатай” гэж тус тус өөрчилсүгэй.**

Хэвлэх

**2 дугаар зүйл.Энэ хуулийг Дайчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.**

Хэвлэх

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2018 оны 02 сарын 02 өдөр | Төрийн ордон, Улаанбаатар хот

## ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “дараалсан 5 жилийн цалин хөлсний нийлбэрийг 60-д” гэснийг “дараалсан 7 жилийн цалин хөлсний нийлбэрийг 84-т” гэж, “5 хүртэл жил” гэснийг “7 хүртэл жил” гэж тус тус өөрчилсүгэй.**

**2 дугаар зүйл.Энэ хуулийг 2018 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ** УЛСЫН **ХУУЛЬ**

2017 оны 02 дугаар сарын 09-ний өдөр Улаанбаатар хот

# ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 9 дэх заалт нэмсүгэй:**

“9/дотоодын цэргийн албаны генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч;”

**2 дугаар зүйл.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн, 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “хилийн” гэсний дараа “ба дотоодын” гэж тус тус нэмсүгэй.**

**3 дугаар зүйл.Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД**